

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

**ХАМРАЛТ, ОРЛОГО ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ, ХӨРӨНГӨ ХАРИУЦСАН АЖИЛТАН
Н.НАСАНЖАРГАЛЫН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТ**

2025 ОН

**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ХАМРАЛТ ОРЛОГО, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН
БАЙЦААГЧ, ЭД ХӨРӨНГӨ ХАРИУЦСАН АЖИЛТАН НАНЗАДЫН НАСАНЖАРГАЛЫН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн /Хүрээгүй бол тайлбар/ түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.							
Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах.							
1.1	Байгууллага орчмын 50м2 газрын цас цэвэрлэгээ, тохижилт, ногоон байгууламжийг хариуцан арчлан хамгаалах		Цэвэрлэгээ, арчлалт хамгаалалт хийсэн тоо	28	28	Байгууллагын орчмын 50м2 талбайн цасыг цэвэрлэж, ногоон байгууламжын хогийг хуваарийн дагуу ногоон байгууламжийн усалгаа арчилгаа хийж цэвэрлэж хэвшсэн.	100
1.2	"Нэг тэрбум мод" аяны хүрээнд байгууллага бүр 50-аас дээш мод		Тарьсан модны тоо	88	50	"Нэг тэрбум мод" аяны хүрээнд өрх бүр нэг мод тарьж, арчлан ургуулж байна.	

	тарих ажлыг зохион байгуулах						100
ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ							
2.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАГЦ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:							
2.1.2 Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, зарцуулах, төвлөрүүлэх, хуваарилах ажлыг хэрэгжүүлнэ.							
2.1.2.1	Арга хэмжээ: Ажил олгогчоос сар бүр ирүүлж буй нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг хүлээн авах, баталгаажуулах. Тоон гарын үсгээр ирүүлэх ажил олгогчийн тоог нэмэгдүүлэх		Тайлан ирүүлбэл зохих ажил олгогчийн тоо	64		Бүртгэлтэй нийгмийн даатгалын шимтгэл төлөгч 67 аж ахуй нэгж байгууллагаас сар бүр нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг цахимаар болон цаасан тайланг хүлээн авч улирал бүр, өглөг авлагын тооцоо нийлэн ажилласан.9 байгууллагын 168,0 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагатай, өглөг үүсээгүй байна.	100
			Тайлан ирүүлсэн ажил олгогчийн тоо	64	Хугацаандаа илгээсэн ажил олгогчийн тоо	Эхний 5 сарын байдлаар 67 ажил олгогч тайлангаа илгээсэн бөгөөд 6 дугаар сарын тайлан илгээх хуулийн хугацаа болоогүй байна.	100

2.1.2.2	Арга хэмжээ: Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлэх	4135,2 мян	Албан журмын даатгуулагчаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөний дүн	3482,1 мян	4135,2 мян	2025 оны 05 сарын байдлаар 1501,4 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтэйгөөс 1688,8 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд хуримтлуулж, 112,4 хувиар биелүүлсэн ба 6 дугаар сарын хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2071,1 сая төгрөгийн орлого бүрдүүлж 110 хувиар биелэхээр байна.	100
			Албан журмын даатгуулагчаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувь	101	100		
		128,4 сая төгрөг	Сайн дурын даатгуулагчийн орлогын төлөвлөгөөний дүн	69,2	128,4 сая	Сайн дурын нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөө 5 дугаар сарын байдлаар 55,9 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 31,3 сая төгрөгийг төвлөрүүлж орлогын төлөвлөгөө 56 хувьтай байна.	50
			Сайн дурын даатгуулагчийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувь	50.6	100		

2.1.3.1	Арга хэмжээ: Ажил олгогчийн хамралтыг нэмэгдүүлэхэд орлого бүрдүүлэх ажлын хэсэгт орж, гэрээний хэрэгжилтийг ханган, санаачлагатай ажиллах.		Батлагдсан төлөвлөгөөний тоо	64	67	Батлагдсан төлөвлөгөөний дагуу хамралтыг нэмэгдүүлэхээр дүүргийн Татварын хэлтсээс ААНБ-ын судалгааг гаргуулан авч ХАОАТ-ын тайлан өгдөг байгууллагыг нийгмийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулан ажилласнаар шинээр 3 ажил олгогчийг нийгмийн даатгалд хамруулсан. Үүнд: 1. 94 дүгээр сургууль 2. Насан туршын суралцахуйн төв 3. Ноён транс ХХК хамруулаад байна.	90
2.1.3.2	Арга хэмжээ: 3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхчүүдийг СДД-д хамруулах		Батлагдсан төлөвлөгөөний тоогоор	8		Эхний хагас жилийн байдлаар 0-3 хүртлэх насны хүүхдээ асарч буй 4 эхчүүдийг сайн дурын даатгалд хамруулсан байна.	80
2.1.3.3	Арга хэмжээ: Албан журмын болон сайн дурын нийгмийн даатгалын даатгуулагчийн тоог нэмэгдүүлэх /шинээр/		АЖ даатгуулагчийн хамралтын тоо	979		Албан журмын даатгуулагч 1350, сайн дурын даатгуулагч 124 хамруулсан байна. Энэ нь өмнөх оны хамралтаас албан журмын даатгуулагч 394, сайн дурын даатгуулагч 33 нэмэгдүүлэн ажилласан байна.	95
			СДД-ийн хамралтын тоо	120			

2.1.3.4	Арга хэмжээ: Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогод эзлэх авлагын хэмжээг 13.0 хувиас хэтрүүлэхгүй байх талаар арга хэмжээ авч ажиллах		Орлогод авлагын эзлэх хувь	19,1	13	2025 оны 05 сарын байдлаар хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийгмийн даатгалын шимтгэлийн сангийн 1744,7 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлсэн ба нийгмийн даатгалын шимтгэлийн 168,0 сая төгрөгийн авлагатай байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогод эзлэх авлагын хэмжээ 9,6 хувьтай байна.	90
2.1.3.5	Арга хэмжээ: Нийгмийн даатгалын шимтгэлийн оны эхний үлдэгдлийг бууруулах /шинээр өр, авлага үүсгэхгүй байх/		Авлага бууруулсан хувь	30,8	30	Оны эхний 155,7 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагаас 37,1 сая төгрөгийг барагдуулсан бөгөөд шинээр боловсролын байгууллагуудын төсөв хүрэлцэхгээс 64,8 сая төгрөгийн өр, бусад 9 ажил олгогчийн 17,1 сая төгрөгийн өр үүссэн байна.	85
2.1.3.6	Арга хэмжээ: Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд шилжсэн шимтгэлийн авлагыг барагдуулан ажиллах					Нийгмийн даатгалын шимтгэлийн насжилт өндөр өртэй Мөнх оргил цамхаг ХХК- 12,6сая төгрөг, Авдрын гол овоо ХХК -6,3 сая, Амарсанаа степ 76,2 гэсэн ажил олгогчдыг 95,2 сая	85

			Авлага барагдуулсан хувь		30	төгрөгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаар шийдүүлэхээр өгсөн байна. Үүнээс Авдрын гол овоо 3,8 сая төгрөгийг барагдуулж байна.	
2.1.3.7	Арга хэмжээ: Сайн дурын нийгмийн даатгалын болон ажил олгогчийн оны эхний өглөгийг барагдуулах.		Өглөг бууруулсан хувь	100	100	Оны эхний байдлаар өглөг нэмэгдээгүй байна.	100
2.1.3.8	Арга хэмжээ: Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтанд хяналт тавих, эд хөрөнгийн тооллогыг хуулийн дагуу хэрэгжүүлж, ил тод тайлагнах		Арга хэмжээний тоо	2	2	Өмч хамгааллын байнгын зөвлөл, өмч хөрөнгийн тооллогоор 102.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө тоологдож, ашиглах боломжгүй, ашиглах хугацаа дууссан, дутагдсан, нэмэгдсэн хөрөнгийн бүртгэлийг ТӨ, ТӨХ маягтын дагуу бүртгэлийг хийж. Эд хөрөнгийн хагас жилийн тооллогыг 2025 оны 06 сарын 20-ны дотор хийж дуусгахаар бэлтгэж байна.	100
2.1.3.9	Арга хэмжээ: Ажил олгогчид нийгмийн даатгалын		Шалгалт хийсэн тоо		5	Нийгмийн даатгалын хуулийн хэрэгжилтийг 2 ажил олгогчид шалгаж ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг	

	хуулийн хэрэгжилтэнд хяналт, шалгалт хийх					хугацаандаа төлөгдөөгүй 1 ажил олгогчийн 0,9 мянган төгрөгийн, 1 ажил олгогч ажилтаны цалин түүнтэй адилтгах орлогыг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд тусгаагүй орхигдуулсан зөрчил илэрсэн.Зөрчлийг арилгуулан шимтгэлийг нөхөн тайлагнуулж, дахин давтан гаргахгүй талаар зааварчилгаа өгч ажилласан.	100
2.1.3.1 0	Арга хэмжээ: Зөрчлийн хэрэг бүртгэлийг явуулах, хяналт тавих, тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргаж, үр дүнг тооцон ажиллах		Зөрчил илэрсэн тоо	-	Зөрчил илэрсэн тоогоор	Ажил олгогч, даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, тайлангийн талаар Зөрчлийн хэрэг бүртгэлт үүсгэхээр зөрчил илрээгүй байна.	100
			Илэрсэн зөрчлийг арилгасан биелэлтийн хувь	-	100		
	Арга хэмжээ: Цахим санд үндэслэн дотоодын хяналт		Хяналт шалгалт хийсэн тоо	2	2	Тэтгэвэр, тэтгэмж тогтоолт, олголтыг мэдээллийн нэгдсэн сан, анхан шатны баримтад үндэслэн дотоодын хяналт шалгалтыг хийж, 4 тэтгэвэр авагчдад 4,6 сая төгрөгийн тэтгэвэр, 1 ажил олгогчийн 2 даатгуулагчдад 0,5 мянган төгрөгийн хөдөлмөрийн	95
			Илрүүлсэн зөрчлийг	-	100		

2.1.3.1 1	шалгалтыг хийж, үр дүнг тооцож ажиллах		арилгасан биелэлтийн хувь			чадвар түр алдсаны тэтгэмжийг тус тус илүү олгосон зөрчил илэрсэн байна. Нийт 5,1 сая төгрөгийн зөрчлөөс 1,3 сая төгрөгийг барагдуулж 3,8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.	
ГУРАВ. НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ							
3.1. Хууль тогтоомж, Засгийн газар болон харъяалах дээд шатны байгууллагын шийдвэрийг хангах ажлын хүрээнд							
3.2. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийж сайжруулна							
3.1.1.	Арга хэмжээ: Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, эцэг эхийн зөвлөлийн гишүүдийг зохих сургалтанд хамруулах, гэр бүлийн өдөр зохион байгуулах, хүүхдүүдийг хүмүүжил төлөвшлийн болон мэргэжлээ зөв сонгох зэрэгт мэргэжлийн байгууллагатай хамтран зөвлөгөө,		Хамрагдсан албан хаагчдын тоо		3	Байгууллагын эцэг эхийн зөвлөлийг газрын даргын 2025-05-20-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулсан бөгөөд дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсээс зохион байгуулсан “Жаргалтай ээж” сургалт, Олон улсын “Гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан ХҮҮХЭД ХАЙР-ИРЭЭДҮЙ уриан дор зохион байгуулсан өдөрлөгийн арга хэмжээнд эцэг эхийн зөвлөлийн гишүүдийг оролцуулсан. Мөн Насан туршийн суралцахуйн төв, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтсээс хүүхдийн хүмүүжил, хүүхэдтэйгээ хэрхэн	100

	сургалтыг байгуулах	зохион		Хамр агдсан хүүхдийн тоо		10	харилцах талаар “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” сургалтыг хамтран зохион байгуулж ажилтан, албан хаагчдыг хамруулсан.Мөн албан хаагчдын хүүхдүүдэд 2025 оны 04-20-ны өдөр “Циркийн тоглолт” үзүүлэн багачуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлсэн.	
				Зохион байгуулсан арга хэмжээний тоо		3		
3.2 Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийж сайжруулна								
3.2.1	Арга хэмжээ: Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх болсонтой холбогдуулан баримт бичгийн MNC 5140- 1,2,3:2021, MNC6395:2022 стандартын хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх			Хэрэгжилтийн хувь	Шинэ ажил	100	Нийгмийн даатгалын ерөнхий газраас Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх болсонтой холбогдуулан 5 удаагийн цахим сургалтанд хамрагдсан.	100

3.2.2	Арга хэмжээ: Нийгмийн даатгалын сан, санхүүгийн анхан шатны бүртгэл хөтлөх, тайлан, мэдээ гаргах ажлыг хэрэгжүүлэх.		Тайлан мэдээний тоо	28	28	Сангийн өр авлагын мэдээг сар бүрийн 03-ны дотор, мөн няравын тайлан, сайн дурын даатгалын болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг хуулийн хугацаанд нь гаргаж ахлах нягтлан бодогчид, мөн хяналт шалгалтын тайланг хуулийн хугацаанд нь гаргаж НДЕГ-т хүргүүлж ажилласан.	100
3.2.3.	Байгууллагын болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлагдсан маягтын дагуу боловсруулан баталгаажуулах, үр дүнг тооцуулах		Хэрэгжилтийн хувь	100	100	Гүйцэтгэлийн төлөвлөгөө нь 3 зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулагдсан байдаг. Гүйцэтгэлийн төлөвлөө, тайланг батлагдсан маягтын дагуу хийж байна.	100

ДӨРӨВ. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ:

д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
-----	----------------------------------	------------------	--------------	-----------------	------------------------------	-------------------

1	Арга хэмжээ: Төрийн албаны зөвлөлөөс долоо хоног бүрийн баасан гаригт зохион байгуулдаг “7:4:10” арга зүйн сургалтуудад хамрагдаж мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн байх	Зохион байгуулагдсан нийт сургалтын 80 хувьд хамрагдсан байх.	8 удаагийн сургалтанд хамрагдсан		Нийгмийн даатгалын ерөнхий газраас 7 хоног бүрийн баасан гаригт зохион байгуулдаг “Хуулийн мэдээллийн цаг”-т хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн.	100
---	--	---	----------------------------------	--	--	-----

БИЕЛЭЛТ БИЧСЭН:

ХАМРАЛТ, ОРЛОГО, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ
ХАРИУЦСАН, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Насанжаргал

(Н.Насанжаргал)

(албан тушаал)

(гарын үсэг)

2025 оны 06 сарын 10 өдөр